



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ЫН  
дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дугаар зүйлийн 18.1.3 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 99 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Монгол наадам цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн холбогдох заалт, хэсэгт дараах байдлаар нэмэлт оруулсугай.

1.1.Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль” гэж, “Хөдөлмөрийн тухай хууль” гэсний дараа “, аялал жуулчлалын тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай,” гэж;

1.2.Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтын “ашиглах” гэсний дараа “Түрээслүүлэх” гэж;

2.Дүрмийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

2.1.Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг: “Монгол наадам цогцолбор” нь Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухайн зорилтуудыг хэрэгжүүлэх, Үндэсний спорт, соёл урлаг, аялал жуулчлалын эвент арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээг дангаар болон хамтран зохион байгуулах, бүтээн байгуулагдсан нийтийн зориулалттай өмч, хөрөнгийг бүртгэх, түрээслэх, зам талбай, эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар /ОНӨТҮГ/ мөн.

2.2. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг: Газар нь Монгол наадам цогцолборын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт, тохиижилтийн ажлыг гүйцэтгэх, хүлээн авах, түүнтэй холбогдон үүсэх эрх, үүрэг, хариуцлагыг хүлэх, Төрийн ёслол, Үндэсний их баяр наадам, үндэсний спорт, соёл урлаг, аялал жуулчлалын эвент арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээг дангаар болон хамтран зохион байгуулах, соёлын биет ба биет бус өвийг хадгалах, хамгаалах, дэлхий дахинд сурталчлан таниулахад өөрийн хувь нэмрээ оруулах;

3.Дүрмийн холбогдох хэсэгт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулж, өөрчилсүгэй.

3.1. Дүрмийн 2.6 дахь хэсгийн “Оюуны өмчийн газарт” гэснийг “Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт” гэж;

3.2.Дүрмийн 4.4 дэх хэсгийн “эрх, үүргийг Захиалагч менежер” гэснийг  
“эрх, үүргийг орлогч дарга” гэж;

3.3.Дүрмийн 5.1 дэх хэсгийн “стандартын дагуу жил бүр гаргаж,  
аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна” гэснийг “стандарт, байгууллагын нягтлан  
бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу жил бүр гаргаж аудитын  
байгууллагаар дүгнэлт гаргуулна” гэж.

4.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга  
бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА

С. АМАРСАЙХАН

